



“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”  
ТӨҮГ-ЫН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ  
Г.ЁНДОН ТАНАА

МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
И-мэйл: comcog@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2023.05.16 № 01/8502.  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Авлигатай тэмцэх газар нь авлигын гэмт хэргийг мөрдөн шалгахгаас гадна авлигын гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөлийг тогтоох, цаашид гарахгүй байх таслан зогсоох ажлын хүрээнд авлигаас ангид байлгах, авлигын гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, төрийн болон төрийн өмчид компанийн үйл ажиллагааг сайжруулах, иргэд, аж ахуйн нэгжид түргэн шуурхай, ил тод, хүнд суртал чирэгдэлгүй хүргэх, нийтийн албан тушаалтны ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.


“Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, хуулийн этгээд, байгууллагын авлигын эрсдэлийн түвшин судалгаа”-аар 25 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудыг хамруулан 6 шалгуураар үнэлэхэд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь эрсдэл өндөр буюу нийт төрийн өмчит компаниудаас 4-т эрэмбэлэгдэж байна.

Авлигад өртөх эрсдэл нэмэгдсэн шалтгааныг судлан үзэхэд үйлдвэрийн бүтцийг оновчтой тодорхойлоогүйгээс дотоод хяналтын үйл ажиллагаа алдагдсан, албан тушаалтнуудыг эрсдэлээс сэргийлэх чиглэлээр хяналт тавих, хариуцлага хүлээлгэх тогтолцоо алдагдсан, хууль тогтоомжийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, үр дүнг тооцдоггүй, нэр бүхий албан хаагчид авлигын гэмт хэрэгт холбогдсон зэрэг нөхцөл байдлууд нөлөөлсөн байна.

Цаашид авлигын гэмт хэрэг, зөрчил дахин гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д заасны дагуу албан зөвлөмж хүргүүлж байна.

Зөвлөмжийн мөрөөр холбогдох арга хэмжээг авч, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д заасны дагуу биелэлт, үр дүнгийн талаар 2023 оны 06 дугаар сарын 15-ны дотор хариу ирүүлнэ үү.

ДАРГА,  
ТЭРГҮҮН КОМИССАР



142303008695

Авлигатай тэмцэх газрын  
2023 оны 09 дугаар сарын 16-ны өдрийн ....  
01/8502 дугаар албан ёсний хавсралт

## АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ЗӨВЛӨМЖ

**Зөвлөмж 1. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын удирдлага зохион байгуулалтын бүтцийн загварыг судалгаа шинжилгээнд үндэслэн газар, хэлтэс, цех, нэгжийн үйл ажиллагааг харилцан уялдаа холбоотой, чиг үүргийн давхардалгүй, хараат бус зарчимд үндэслэн олон улсын корпорацуудын туршлагад тулгуурлан боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулах.**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 283 дугаар тогтоолын хавсралтаар “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтцийг өөрчлөн батлагдсан байна. Уг өөрчлөлтөөр өмнөх Монгол оросын хамтарсан үйлдвэрийн бүтцээс дордуулсан, компанийн засаглалын талаас ухралт хийж, хяналтын нэгжүүдийг хараат бусаар үйл ажиллагаа явуулах боломжийг хааж, нэг хүнд эрх мэдлийг төвлөрүүлсэн гэж үзэхээр байна.

Тухайлбал, Монгол-Оросын хамтарсан үйлдвэрийн бүтцэд дотоод хяналтын нэгж, чанарын хяналтын нэгж нь ерөнхий захирлын шууд удирдлага доор байсныг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 283 тогтоолоор батлагдсан бүтцийн өөрчлөлтөөр Ерөнхий захирлын доор Тамгын газрын дарга, Ерөнхий инженерийн орон тоог бий болгосон байна.

Тамгын газрын даргын харьяанд Хөрөнгө оруулалт, Худалдан авах ажиллагааны бодлогын газар, Хамтын ажиллагаа, Нийгмийн харилцааны газар, Хүний нөөц, Эдийн засаг, Санхүү нягтлан бодох бүртгэл, Хуулийн хэлтэс, Дотоод хяналт гэх зэргээр 5 газар, 9 хэлтэс, 8 байгууллага, 2 цехийг хариуцаж, төсөв, худалдан авалт, хяналтыг нэг доор, нэг хүний мэдэлд хариуцуулан, авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэлтэй ажлын байрыг бий болгосон байна.

Ерөнхий инженерийн харьяанд Үйлдвэрлэл техникийн бодлого, төлөвлөлтийн газар, Стратеги, хөгжлийн газар, Үйлдвэрлэлийн хэлтэс, Техникийн хэлтэс, Баяжуулах үйлдвэрлэл, Чанарын хяналт зэрэг 2 газар, 10 хэлтэс, 7 цех, 2 хүрээлэнг хариуцуулсан байгаа нь үйлдвэрийн эцсийн бүтээгдэхүүний, үйлдвэрлэлийн процессын явцын болон бусад бүтээгдэхүүний чанарын хяналтыг нэг доор төвлөрүүлж, бүтээгдэхүүний чанарт хөндлөнгийн хяналтад тавих боломжгүй болгосон байна. Өөрөөр хэлбэл Ерөнхий инженер нь өөрөө үйлдвэрлээд өөртөө хяналт тавих зохион байгуулалтын бүтэцтэй болсон нь албан тушаалтан өөртөө болон бусдад давуу байдал олгох, албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх зэрэг авлигын гэмт хэрэг, зөрчил үүсэх нөхцөл бүрдсэн байна.

Удирдлага зохион байгуулалтын бүтцийг судалгаа, дүн шинжилгээнд тулгуурлан үндэслэлтэй, компанийн зорилго, үйл ажиллагааг хангахад чиглэсэн чиг үүрэг бүхий нэгжүүд байгуулахад илүү анхаарч, ямар чиг үүрэг бүхий нэгж алдагдсаны улмаас компанид хэрхэн сөрөг үр дагавар үүсэх, цаашид үр дагавар, үр дүнгийн шинжилгээ хийж байх шаардлагатай байна.

“Эрдэнэт үйлдвэр” ХХК буюу хамтарсан үйлдвэрийн статустай ажиллаж байх үед Үйлдвэр техникийн нэг хэлтэс 10-15 ажилтантай гүйцэтгэж байсан ажлыг одоо нэг газар, гурван хэлтэс, 40-50 хүнтэй хийдэг болсон. Ерөнхий захиргаа, удирдлагын орон тоо данхайж, ажил үүргийн давхардал бий болж, удирдлагын олон шат дамжлага, хүнд суртал их болсон байна. Тухайлбал, Нийгмийн асуудлыг 2-3 ажилтан

өмнө нь хариуцаж байсныг одоо Хамтын ажиллагаа, нийгмийн харилцааны газар 10-15 ажилтан хариуцаж байна.

**Зөвлөмж 2. Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх** Ёс зүйн хорооны бүрэлдэхүүнд ажилтны төлөөллийг нэмэгдүүлэх, хорооны хурлыг цаг тухайд нь хийж, үйл ажиллагааг тогтмолжуулах.

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т Монгол улсын Хүний эрхийн үндэсний комиссын гишүүний 2021 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн 4/55 тоот зөвлөмжид “Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн”-д ажилтны төлөөллийн тоог нэмэгдүүлж, шинэчлэн батлуулах ажлыг зохион байгуулах чиглэл болгосныг одоог хүртэл хэрэгжүүлээгүй, ажилтны төлөөллийг ёс зүйн хорооны гишүүнээр нэмээгүй ёс зүйн зөвлөлийн есөн гишүүний найм нь үйлдвэрийн газрын бүтцийн нэгжийн удирдах албан тушаалтнууд, нэг нь ажилтны төлөөлөл байгаа нь Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга байна.

Энэ нь ёс зүйн зөвлөл ажилтнуудаас ирүүлсэн гомдлыг шийдвэрлэхэд хэт нэг талыг барих, гомдлыг шийдвэрлэхгүй дарах, гомдлыг буцаах эрсдэлийг дагуулж байна. Мөн ёс зүйн хороог тогтмол хуралдуулдаггүй буюу ёс зүйн холбогдолтой гомдол мэдээллийг хугацаанд шийдвэрлэхгүй удааж, гомдлыг нэгдсэн байдлаар нэг хурлаар хамтад нь шийдэж байна. Тухайлбал, Ёс зүйн хороо нь 2021 оноос хойш 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдөр 1 удаа хуралдсан байна. Ёс зүйн хороонд 2021 онд 5 өргөдөл ирснээс 3 гомдлыг Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангуулах, Ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журмын 3.3.2-т зааснаар эрх бүхий байгууллагаар хянан шийдвэрлэгдэж байгаа маргаан үндэслэлээр буцааж, 2 гомдлыг Ёс зүйн хорооны 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн буюу тухай гомдол гарснаас хойш 7 сарын дараа асуудыг шийдвэрлэсэн байна.

Ёс зүйн хороонд 2022 онд 6 өргөдөл гомдол ирснээс 1 гомдлыг Ёс зүйн хорооны 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэж, 1 гомдлыг гомдол гаргагч гомдлоосоо татгалзаж буцааж, 1 гомдлыг хуулийн хэлтэс хариу хүргүүлж шийдвэрлэсэн бол 1 гомдлыг Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангуулах, Ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журмын 3.3.2-т зааснаар эрх бүхий байгууллагаар хянан шийдвэрлэгдэж байгаа маргаан үндэслэлээр буцааж, 2 гомдлыг Ёс зүйн хорооны журамд өөрчлөлт оруулах, Ёс зүйн зүйн хуулийн төсөлтэй холбогдуулан 9 сар шийдвэрлээгүй байна. 2023 онд 1 гомдол ирснийг журмын шаардлага хангаагүй үндэслэлээр буцаасан байна.

**Зөвлөмж 3. Эмнэлгийн гүйцэтгэх захирлаар тухайн албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжил, мэргэшил, ур чадвар, ажлын туршлага хангасан иргэнийг сонгон шалгаруулж томилох.**

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.1, 16.3.2, 16.3.2, 16.3.3, 16.3.7 дугаар зүйл, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/252 дугаар тушаалаар батлагдсан “Эрдэнэт медиал” эмнэлгийн дүрмийн 3.4.3 дугаар зүйлд нийцэхгүй байна. Цаашид ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлж, гүйцэтгэх захирлын томилгоог хуульд нийцүүлэх шаардлагатай байна.

**Зөвлөмж 4. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргахдаа мэдэгдэл, тайлбар гаргаж хэвших, зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцох.**

“Эрдэнэт медиал эмнэлэг” ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Бат-Энх нь 2023 оны 02 дугаар 15-ны өдрийн А/32 дугаар тушаалаар өөртөө 1.540.000 төгрөгийг урамшуулал болгон олгосон байна. Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 11 дүгээр зүйлийн 11.1-т заасныг тус тус зөрчсөн байна. Иймд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг

сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2-т заасны дагуу арга хэмжээ авах.

**Зөвлөмж 5. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслэхдээ сонгон шалгаруулалтын журам, жишиг үнэд нийцүүлж түрээслэх, журам зөрчиж байгуулсан түрээсийн гэрээг цуцлах, төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх гэрээ байгуулахад тавих хяналтыг сайжруулах.**

“Эрдэнэт медиал эмнэлэг” ХХК дээр удирдамжийн хүрээнд ажиллахад 2022 онд хоёр хуулийн этгээдтэй байгуулсан түрээсийн гэрээтэй танилцахад түрээслэгчийг сонгоход нээлттэй сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй, үнийг тогтоохдоо төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох тухай тогтоолыг хэрэгжүүлээгүй бага үнээр түрээсэлж бусдад давуу байдал олгосон байна.

Тухайлбал, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын дэргэдэх “Эрдэнэт медиал” эмнэлэг нь ЭМЭ/2022/01 дугаартай Төрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээг “Оддөл” ХХК-тай байгуулахдаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн Дугаар 51 тогтоолын хавсралтаар батлагдсан “Сонгон шалгаруулалтын жишиг баримт бичиг батлах тухай журам”-д заасан “Төрийн өмчит хуулийн этгээд нь сонгон шалгаруулалтын зарын маягтыг өдөр тутмын (тухайн орон нутгийн сонин) байгууллагын албан ёсны цахим хуудсанд ил тод нээлттэй нийтэлнэ” гэж заасныг зөрчиж Эрдэнэт үйлдвэртэй гэрээтэй ажилладаг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Сэлэнгэ амралт аялал жуулчлалын цогцолбор, Оддөл ХХК, Таятан хас фүүдс ХХК, Цахир яруу ХХК-д үнийн санал авах албан бичиг илгээж, үнийн санал авч харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж өрсөлдөөнийг хязгаарлаж давуу байдал олгосон байна. Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн дугаар 49 тогтоолоор Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай тогтоолоор заасан худалдаа, үйлчилгээний талбайг аймгийн төвд 7,000 төгрөгөөр түрээслэх, цайны газрын түрээсийг 6,000 байхаар тусгасан байхад “Оддөл” ХХК-тай байгуулсан ЭМЭ/2022/01 дугаартай Төрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний 1.1-д зааснаар 50м2 талбайг кофе шопын зориулалтай түрээслэхдээ тус гэрээний 3.1 Энэхүү гэрээний 1.2-т заасан түрээсэлсэн эд хөрөнгийн түрээсийн (НӨАТ багтаагүй) бөгөөд 1 м.кв талбайн 1 (нэгж хөрөнгийн) төлбөр нь 6,000 / зургаан мянга/ төгрөг 1(нэг) сарын түрээсийн төлбөр нь 1,122,000 /нэг сая нэг зуун хорин хоёр мянга /төгрөг байна гэж нийтэд нь нэг үнэ баримталж үйлчилгээний талбайг 6,000 төгрөгөөр түрээсэлж төрд хохирол учруулсан гэж үзэхээр байна.

**Зөвлөмж 6. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын харьяа “Эрдэнэт медиал эмнэлэг” ХХК-ийн дор дурдсан нэр бүхий албан тушаалтныг Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд хамруулж, мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргуулах, хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг мөрдүүлж ажиллах.**

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн 138 дугаар тогтоолоор байгуулсан “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын “Эрдэнэт медиал эмнэлэг” ХХК-ийн удирдах албан тушаалтнууд нь “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудын нэрсийн жагсаалтад багтаагүй бөгөөд 2022 оны Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргаагүй байна.

**“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ХАСХОМ гаргавал зохих албан тушаалын жагсаалтад нэмэх шаардлагатай “Эрдэнэт медиал эмнэлэг” ХХК-ийн 13 удирдах албан тушаалын мэдээлэл**

д/д	Нэр	Харьяалагдах алба тасаг нэгж	Албан тушаалын нэр	Мэдүүлэг гаргавал зохих албан тушаалтанд хамруулах
1	П.Сувдаа	Удирдлага	Эмнэлгийн тусламж үйлчилгээ хариуцсан орлогч захирал	Шаардлагатай
2	Л.Туул	Удирдлага	Үйл ажиллагаа хариуцсан орлогч	Шаардлагатай
3	Д.Отгон Эрдэнэ	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын алба	Чанар аюулгүй байдлын албаны дарга	Шаардлагатай
4	Г.Батжаргал	Яаралтай тусламж, эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлгийн тасаг	МЭЭЯТ - ийн их эмч, Тасгийн эрхлэгч	Шаардлагатай
5	Т.Амгаланбаяр	Амбулаторийн тасаг	ТХЧХХ - н мэс заслын их эмч, тасгийн эрхлэгч	Шаардлагатай
6	Г.Ганболд	Мэс заслын нэгдсэн тасаг	Тасгийн эрхлэгч, Цээжний хөндийн мэс заслын их эмч	Шаардлагатай
7	В.Алтанцэцэг	Хэвтэн эмчлүүлэх тасаг	Мэдрэлийн их эмч, Тасгийн эрхлэгч	Шаардлагатай
8	Б.Мөнхжаргал	Урьдчилан сэргийлэх алба	Дотрын их эмч, тасгийн эрхлэгч	Шаардлагатай
9	Х.Дэнсмаа	Дүрс оношилгооны тасаг	Дүрс оношилгооны их эмч, Тасгийн эрхлэгч	Шаардлагатай
10	А.Булганчимэг	Сувилахуйн алба	Сувилахуйн албаны дарга	Шаардлагатай
11	Л.Баттогтох	Эм зүйн алба	Албаны дарга, Клиникийн эм зүйч	Шаардлагатай
12	Б.Цэндмаа	Лабораторийн тасаг	Тасгийн эрхлэгч, Эмгэг судлалын их эмч	Шаардлагатай
13	М.Уранчимэг	Нэгдсэн ариутгал цэвэрлэгээний тасаг	Тархвар судлаач, Эрүүл ахуйч, Тасгийн эрхлэгч	Шаардлагатай

**Зөвлөмж 7. Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2-т заасны дагуу “Эрдэнэт медиал эмнэлэг” ХХК-ийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог эрх бүхий албан тушаалтныг компанийн дүрэмд тодорхойлох.**

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/252 дугаартай тушаалаар баталсан “Эрдэнэт медиал эмнэлэг”-ийн дүрэмд эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг тусгаагүй байна.